



МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 4/46

Улаанбаатар хот

Боловсрол, соёлын хяналтын
хуудас батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Хяналт шалгалтын үйл ажиллагаанд хэрэглэгдэх шинэчлэн боловсруулсан 6.1, 6.2, 6.3, 6.4, 6.7 кодтой хяналтын хуудсыг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан хяналтын хуудсуудыг хяналт шалгалтад хэрэглэх, улсын байцаагчдыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Эрүүл мэнд, боловсрол, соёлын хяналтын газар, Эрсдэлийн удирдлага, стратеги төлөвлөлтийн газар, аймаг, нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дарга нарт үүрэг болгосугай.

3. Хяналтын хуудас шинэчлэн баталсантай холбогдуулан Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2015 оны "Хяналтын хуудас батлах тухай" 540 дүгээр тушаалаар батлагдсан 6.1, 6.4, 6.7, 2015 оны "Хяналтын хуудас батлах тухай" 542 дугаар тушаалаар батлагдсан 6.2 кодтой хяналтын хуудсуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4. Хяналтын хуудасны ашиглалт, хяналт шалгалтын явц, мэдээллийн сангийн бүрдүүлэлт, дүн шинжилгээ хийсэн байдалд хяналт тавьж ажиллахыг Эрсдэлийн удирдлага, стратеги төлөвлөлтийн газар /М.Наранбат/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Н.ЦАГААНХҮҮ

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын
2017 оны 02 дугаар сарын 16 ны өдрийн
А/46 тоот тушаалын хавсралт

ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛСАН ХЯНАЛТЫН ХУУДАСНЫ НЭР, КОД

| № | Хяналтын хуудасны код | Хяналтын хуудасны нэр | Хяналтын хуудасны тоо |
|-----------------------------------|-----------------------|---|-----------------------|
| 1 | 6.1 | Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас | 1 |
| 2 | 6.2 | Ерөнхий боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас | 1 |
| 3 | 6.3 | Мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас | 1 |
| 4 | 6.4 | Дээд боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас | 1 |
| 5 | 6.7 | Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт, хамгаалалтыг шалгах хяналтын хуудас | 1 |
| Нийт хяналтын хуудасны тоо | | | 5 |